

ЗӨВШӨӨРСӨН

ЗАСАГ ДАРГА

Н.БЯМБАДОРЖ

2024 оны -р сарын ны өдөр

**ЗАВХАНМАНДАЛ СУМАНД ХАЛУУН УСНЫ БАРИЛГА БАРИХ
ТӨСӨЛТ АЖЛЫН ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ**

2023,12,29

Байршил: Завханмандал сумын төв Нуга баг

Хугацаа: 2024 он

Гүйцэтгэх ажил: Сумын төвийн халуун усны барилга барих.

Техникийн шаардлага:

- Хэмжээ- 10м* 8м хэмжээтэй.
- Хаалга- 2 сайн чанарын бүргэд хаалга.
- Хана- үндсэн хийц нь зориулалтын стандартын блок, гадна талаас нь дулаалж өнгөлгөөний сайтинг-аар өнгөлнө. Дотор талыг нь плитагаар өнгөлнө.
- Цонх, агааржуулагч- стандартын дагуу агааржуулалтын системтэй, цонх гэрэлтүүлэг сайн орохоор өдрийн цагаар гэрэл асаахааргүй гэрэлтүүлэг сайн нэвтрүүлэх вакум цонхтой байна.- 5ширхэг цонх.
- Дээвэр: Дээврийн банз нь бүрэн байх ба төмөр дээр нь хадаж бороо ус гоожихгүй налуу дээвэрлэнэ. Борооны ус зайлуулагч хийсэн байна. Дээврийн бэхэлгээг стандартын дагуу хийнэ.
- Шал- бетороор бүрэн цутгасан, Плитагаар өнгөлсөн байна.
- Халаалт- Халаалтын системийг бүрэн тавьж нэгдсэн халаалтын шугамтай холбосон байна. / 10-15-н метр зайтай нэгдсэн шугам/
- Бохирын шугамыг шийдсэн байна. / Газарт 10тн оос багагүй кантенер булах /
- Гэрэлтүүлэг: Өрөө болгон гэрэлтүүлэг , унтраалга, разеткатай байна. Стандарын дагуу гэрэлтүүлэгийн мантажийг
- Халуун усны өрөө- Гэр бүлийн 1, нэг хүний 1 нийт 2 өрөө нь /Монгол улсын халуун усны стандарт MNS 5163:2002 / стандартын шаардлагыг бүрэн хангасан байна.
- Сауны өрөө 1, стандартыг хангасан байх
- Коридортой / хүлээлгийн сандал , үйлчилгээний ширээ /
- ОО -ын өрөө: Стандартын шаардлага хангасан гар угаах тосгууртай эрэгтэй 1 эмэгтэй 1 00 өрөө байна.
- Угаалагын өрөө: Хувцас угааллагын өрөө халуун хүйтэн усны кранттай, ус зайлуулах шугамтай, разетка 3 ширхэг байна.Автомат угаалгын машин 1ш ийг суурьлуулсан байх . / 15кг аас доошгүй хүчин чадалтай /
- Үсчингийн өрөө: 2 ширхэг разеткатай, цэвэр бохир усны шугамтай байна
- Сангийн өрөө: цахилгаан болон сантехникийн нэгдсэн удирдлага байна. Атмар, агшин зуурын халаагч, орчин үеийн шийдэлтэй байх /

Завханмандал сумын Засаг даргын тамгын газар



<https://masm.gov.mn/bug/>
Хэлтсийн цахим хаяг

MNS 5163 : 2002

ХАЛУУН УСНЫ ҮЙЛЧИЛГЭЭ, ЕРӨНХИЙ ШААРДЛАГА

Энэхүү стандартаар нийтийн халуун усны үйлчилгээнд тавих нийтлэг шаардлагыг тогтооно.

Нийтийн халуун усны үйлчилгээ нь зөвхөн шүршүүртэй байхаас гадна өрөөний багтаамжийн хүчин чадлаас нь хамааруулан дараахь байдлаар ангилна. Үүнд: Өрөөний багтаамж хүчин чадлаар нь:

Нийтийн өрөө.

Нэг хүний өрөө гэж ангилна.

Шүршүүр: Усыг маш нарийн цацрагаар шүршиж гаргах зориулалтын хэрэгсэл

Нийтийн өрөө: Олон хүн зэрэг орох зориулалтаар олон шүршүүрээр тоноглогдсон өрөө

Нэг хүний өрөө: Нэг хүн орох зориулалтаар шүршүүрээр тоноглогдсон өрөө

Усанд орох өрөөний температур нь 20-22ᵒC, үйлчилгээний газрын температур нь 18-20ᵒC байна.



Баян-Өлгий Стандарт, хэмжил зүйн хэлтэс

<https://estandard.gov.mn/>
Стандартын мэдээллийн цахим хаяг



<https://masm.gov.mn/bug/>
Хэлтсийн цахим хаяг

MNS 5164 : 2010 САУН. ЕРӨНХИЙ ШААРДЛАГА

Энэ стандарт нь цахилгаан халаагуур бүхий сауны газар болон цахилгаан халаагуур бүхий саунтай аж ахуйн нэгж, байгууллагын үйлчилгээнд тавих нийтлэг шаардлагыг тогтооход хамаарна.

Барилга байгууламжид тавих шаардлага /зарим хэсгээс/

Эрх бүхий байгууллагаас баталсан зураг төслийн дагуу баригдсан үйлчилгээний шаардлага хангахуйц барилга байгууламжтай байна.

Сауны газрын доторлогоонд 16 мм-ээс багагүй зузаан, 60 мм-ээс багагүй өргөнтэй найлзуурхайгүй, сайтар зүлгүүрдсэн, ямар нэгэн өнгөлөгч болон хамгаалагч бодис түрхээгүй, туршилт, эдэлгээнд хэрэглээгүй мод хэрэглэнэ.

Сауны хана, таазыг модоор хийх бөгөөд хана, тааз нь заавал дулаан, уур тусгаарлагчтай байна.

Сауны ууранд суух өрөөний талбайг нэг хүнд 0,8 м² -ээс багагүй талбай ноогдохоор, өндөр нь дулааны тэнцвэр болон эдийн засгийн үр ашгийн үүднээс дээд тал нь 2,0 м хүртэл байхаар тооцож төлөвлөнө. Ууранд суух өрөөний хаалганы дээд хэсэгт нь дунджаар (0,25x0,30) м харьцаатай, татаж нээгддэг салхивчтай байна.



Баян-Өлгий Стандарт, хэмжил зүйн хэлтэс

<https://estandard.gov.mn/>
Стандартын мэдээллийн цахим хаяг